



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 23 өдөр

Дугаар

1/180

Улаанбаатар хот

Газар албадан чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5, 57 дугаар зүйлийн 57.4, 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, Төсвийн тухай хуулийн 14.2.3 Захиргааны ерөнхий хуулийн 27.5, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэр 1 дүгээр хороо 13 дугаар байрны хойд талд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг хааж зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр барьсан өргөтгөлийг албадан буулгаж, газар чөлөөлөхийг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ж.Тамир)-д зүүрэг болгосугай.

2. Газрын зөрчил арилгах, газар чөлөөлөх талаар арга хэмжээ авч ажиллахад төрийн байгууллагын үйл ажиллагааг саадгүй явуулах, нийтийн эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, зохих арга хэмжээ авч хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн нэгдүгээр хэлтэс (Ц.Түвшинжаргал), Замын цагдаагийн хэлтэс (Г.Золжаргал)-т тус тус даалгасугай.

3. Дээрх газар албадан чөлөөлөх ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг тухай бүр дүүргийн Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т зөвшөөрсүгэй.

4. Холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Хурцбаяр)-т даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010741